

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар A/35

Өлгий

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 12 дугаар заалт, Гүйцэтгэлийн гэрээний 5.1.4, 5.1.5, 5.2.8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн гэрээг дүгнэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /сум, өрх/-ийн эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Ж.Нурбота/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д даалгасугай.

ДАРГА



Н.САКЕН

Эрүүл мэндийн газрын даргын  
2023 оны 07 сарын 26 өдрийн 135 тоот  
тушаалын ... хавсралт



### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: / Сум /өрх/-ийн эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

#### Гишүүд:

- Нийгмийн эрүүл мэндийн хэлтэсийн дарга, Эрүүл мэндийн боловсрол сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэсийн дарга, Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, эмнэлгийн магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эмийн хангамж, эмнэлгийн хэрэгслийн хангамж, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- Эх барих, эмэгтэйчүүд, нярайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эм, эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан ажилтан
- Яаралтай тусламж, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Сувилахуй болон хөнгөвчлөх, тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан ажилтан
- Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Сүрьеэ, БЗДХ-ын тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан
- Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан ажилтан
- Дархлаажуулалтын их эмч